



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/73/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2021 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Гэрээт ажилтан	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ц.Лүндэгмаа Цахим хаяг: auditlundegmaa@gmail.com
---	---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.07.24 № 1-6/102

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ТУНГАЛАГТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	240,459,625.70	340,106,774.88
33	АВЛАГА	31,641,389.00	125,747,681.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	19,613,438.18
335	Бусад авлага	31,641,389.00	106,134,243.00
3351	Байгууллагаас авах авлага	31,641,389.00	106,134,243.00
34	УРЬДЧИЛГАА	6,920,000.00	6,920,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	6,920,000.00	6,920,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,920,000.00	6,920,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	201,898,236.70	207,439,093.70
351	Түүхий эд материал	101,848,913.50	102,977,913.50
35110	Тусгай зориулалттай материал	101,848,913.50	101,848,913.50
35130	Эм боох материал	-	1,129,000.00
354	Хангамжийн материал	100,049,323.20	104,461,180.20
35410	Бичиг хэргийн материал	11,136,200.00	10,356,900.00
35420	Аж ахуйн материал	62,927,072.20	80,214,301.20
35430	Сэлбэг хэрэгсэл	2,404,000.00	8,800.00
35440	Түлш, шатах тослох материал	10,386,321.00	4,649,449.00
35470	Бусад хангамжийн материал	13,195,730.00	9,231,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,856,617,316.78	7,813,190,625.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,856,617,316.78	7,813,190,625.43
392	Биет хөрөнгө	6,502,996,566.78	7,457,145,750.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,048,602,144.50	2,936,300,828.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(70,760,627.89)	(127,310,895.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,334,800.00	191,834,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,620,072.00)	(151,020,871.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	164,954,434.48	175,426,879.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(119,651,085.91)	(133,442,723.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,508,880.64	119,425,367.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,621,094.72)	(65,188,782.06)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,630,537,204.00	3,413,755,918.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(322,214,293.30)	(618,680,791.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,971,809,401.55	2,819,417,161.65
39215	Хуримтлагдсан элэгдэл	(907,753,324.57)	(1,105,241,339.79)
39217	Ном	1,870,200.00	1,870,200.00
393	Биет бус хөрөнгө	353,620,750.00	356,044,875.00
39301	Програм хангамж	13,764,000.00	14,136,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,585,250.00)	(11,533,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	353,992,000.00	353,992,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,097,076,942.48	8,153,297,400.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,331,547.04	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,331,547.04	-
413	Өглөг	3,331,547.04	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,331,547.04	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,093,745,395.44	8,153,297,400.31
51	Засгийн газрын хувь оролцоо	7,093,745,395.44	8,153,297,400.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	593,513,848.97	593,513,848.97
51101	Өмч: - төрийн	593,513,848.97	593,513,848.97

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

512	Хуримтлагдсан үр дүн	6,080,019,864.35	7,139,571,869.22
51210	Өмнөх үеийн үр дүн	6,080,019,864.35	6,084,376,265.57
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,055,195,603.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	420,211,682.12	420,211,682.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,097,076,942.48	8,153,297,400.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,704,860,452.73	3,474,616,173.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	561,413,065.73	1,694,818,822.70
120	Нийтлэг татварын бус орлого	561,413,065.73	1,694,818,822.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	561,413,065.73	1,694,818,822.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	139,720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,144,026.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	557,269,039.73	1,694,679,102.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,143,447,387.00	1,779,797,351.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,498,487.00	605,021,551.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	66,316,735.00	396,135,141.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,181,752.00	208,886,410.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,010,948,900.00	1,174,775,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,010,948,900.00	1,174,775,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,135,801,620.07	2,306,316,818.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,135,801,620.07	2,306,316,818.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,118,233,337.18	2,304,608,845.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608,624,519.81	706,964,407.84
210101	Үндсэн цалин	526,957,404.81	516,704,407.84
210105	Гэрээт ажлын хөлс	81,667,115.00	190,260,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,774,775.00	102,320,800.00
210201	Тэтгэврийн даатгал	46,433,825.00	74,468,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,723,414.00	6,963,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,201,659.00	5,570,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,328,691.00	1,392,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,087,186.00	13,926,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,920,792.57	76,315,133.00
210301	Гэрэл, цахилгаан	6,815,129.57	8,419,724.00
210302	Түлш, халаалт	48,813,574.00	60,449,655.00
210303	Цэвэр, бохир ус	7,292,089.00	7,445,754.00

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	105,028,085.77	113,331,712.94
210401	Бичиг хэрэг	12,557,690.00	47,732,800.00
210402	Тээвэр, шатахуун	23,330,047.00	27,249,818.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,175,887.77	14,663,867.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	55,724,461.00	23,445,227.00
2105	Нормативт зардал	400,000.00	110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	422,098,576.00	8,820,370.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	190,000.00	-
210604	Урсгал засвар	421,908,576.00	8,820,370.00
2107	Томилолт, зочны зардал	5,250,662.00	2,079,100.00
210702	Дотоод албан томилолт	5,250,662.00	2,079,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165,171,761.00	649,341,655.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	164,549,141.00	648,283,263.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	406,020.00	525,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,600.00	153,392.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	671,964,165.03	645,325,666.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,798,624.00	5,621,275.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,752,500.00	3,338,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	639,413,041.03	636,366,391.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,568,282.89	1,707,973.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,873,348.00	1,527,248.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,873,348.00	1,527,248.50
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,694,934.89	180,725.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,694,934.89	180,725.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(430,941,167.34)	1,168,299,354.81
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	144,731,846.53	113,103,751.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	144,731,846.53	113,103,751.16
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(144,731,846.53)	(113,103,751.16)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(575,673,013.87)	1,055,195,603.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,148,027,013.00	1,801,678,460.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,144,026.00	139,720.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,144,026.00	139,720.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,144,026.00	139,720.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	139,720.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,144,026.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,143,882,987.00	1,801,538,740.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	132,934,087.00	626,762,940.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	66,316,735.00	427,776,530.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,617,352.00	198,986,410.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,010,948,900.00	1,174,775,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,010,948,900.00	1,174,775,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,139,196,013.00	1,788,121,280.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,139,196,013.00	1,788,121,280.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,089,759,689.11	1,688,518,196.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,240,982.77	724,068,498.74
210101	Үндсэн цалин	467,951,560.77	533,808,498.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	374,584.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	136,914,838.00	190,260,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,230,775.00	102,320,800.00
210201	Тэтгэврийн даатгал	52,479,075.00	74,468,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,750,100.00	6,963,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,500.00	5,570,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,187,200.00	1,392,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,875,900.00	13,926,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,920,792.57	76,315,133.00
210301	Гэрэл, цахилгаан	6,815,129.57	8,419,724.00
210302	Түлш, халаалт	48,813,574.00	60,449,655.00
210303	Цэвэр, бохир ус	7,292,089.00	7,445,754.00
2104	Хангамж, бараа материалын зардал	71,018,854.77	58,045,809.94
210401	Бичиг хэрэг	18,809,500.00	14,079,840.00
210402	Тээвэр, шатахуун	26,300,952.00	18,510,532.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,192,087.77	14,621,967.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,476,315.00	10,593,470.00
2105	Нормативт зардал	1,900,000.00	1,250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,900,000.00	1,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,105,340.00	10,108,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	377,000.00	108,000.00
210604	Урсгал засвар	15,728,340.00	10,000,000.00
2107	Томиллолт, зочны зардал	5,250,662.00	2,079,100.00
210702	Дотоод албан томиллолт	5,250,662.00	2,079,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	217,344,158.00	701,496,171.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	216,285,538.00	700,437,779.16
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	436,000.00	336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	406,020.00	525,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,600.00	153,392.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	44,000.00

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,748,124.00	12,834,684.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,798,624.00	8,373,934.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,949,500.00	4,460,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,436,323.89	99,603,083.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	3,188,115.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	3,188,115.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	47,336,323.89	96,414,968.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,694,934.89	180,725.16
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,641,389.00	96,234,243.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,831,000.00	13,557,180.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,831,000.00	13,557,180.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,831,000.00	13,557,180.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,831,000.00	13,557,180.00
222001	Тоног төхөөрөмж	-	10,020,900.00
223001	Бусад хөрөнгө	8,831,000.00	3,536,280.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,831,000.00)	(13,557,180.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,513,848.97	423,514,632.42	6,652,389,927.92	7,669,418,409.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,302,950.30	3,302,950.30
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	593,513,848.97	423,514,632.42	6,655,692,878.22	7,672,721,359.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(3,302,950.30)	-	(3,302,950.30)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(575,673,013.87)	(575,673,013.87)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,513,848.97	420,211,682.12	6,080,019,864.35	7,093,745,395.44
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	593,513,848.97	420,211,682.12	6,080,019,864.35	7,093,745,395.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,356,401.22	4,356,401.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	593,513,848.97	420,211,682.12	6,084,376,265.57	7,098,101,796.66
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,055,195,603.65	1,055,195,603.65
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,513,848.97	420,211,682.12	7,139,571,869.22	8,153,297,400.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү дүн	Харьцуулалт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,175,798,800.00	1,174,915,520.00	883,280.00	99.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,175,798,800.00	1,174,915,520.00	883,280.00	99.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,175,798,800.00	1,174,734,794.84	1,064,005.16	99.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	724,068,500.00	724,068,498.74	1.26	100.00
210101	Үндсэн цалин	533,808,500.00	533,808,498.74	1.26	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	190,260,000.00	190,260,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,320,800.00	102,320,800.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	74,468,300.00	74,468,300.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,963,100.00	6,963,100.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,570,500.00	5,570,500.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,392,600.00	1,392,600.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,926,300.00	13,926,300.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,673,600.00	76,315,133.00	358,467.00	99.53
210301	Гэрэл, цахилгаан	8,375,000.00	8,419,724.00	(44,724.00)	100.53
210302	Түлш, халаалт	60,699,600.00	60,449,655.00	249,945.00	99.59
210303	Цэвэр, бохир ус	7,599,000.00	7,445,754.00	153,246.00	97.98
2104	Хангамж, бараа материалын зардал	55,700,900.00	55,485,809.94	215,090.06	99.61
210401	Бичиг хэрэг	13,250,000.00	13,249,840.00	160.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	16,859,700.00	16,780,532.00	79,168.00	99.53
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,751,200.00	14,621,967.94	129,232.06	99.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,600,000.00	10,593,470.00	6,530.00	99.94
2105	Нормативт зардал	400,000.00	400,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,700,000.00	20,681,900.00	18,100.00	99.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,700,000.00	10,681,900.00	18,100.00	99.83
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,081,400.00	2,079,100.00	2,300.00	99.89
210702	Дотоод албан томилолт	2,081,400.00	2,079,100.00	2,300.00	99.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	189,353,600.00	188,922,803.16	430,796.84	99.77

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	187,952,600.00	187,864,411.16	88,188.84	99.95
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	336,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	525,000.00	525,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	153,392.00	296,608.00	34.09
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	44,000.00	46,000.00	48.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,460,750.00	39,250.00	99.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,460,750.00	39,250.00	99.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	180,725.16	(180,725.16)	
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	180,725.16	(180,725.16)	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		180,725.16	(180,725.16)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,175,798,800.00	1,174,915,520.00	883,280.00	99.92
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,174,798,800.00	1,174,775,800.00	23,000.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,174,798,800.00	1,174,775,800.00	23,000.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	139,720.00	860,280.00	13.97
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	139,720.00	860,280.00	13.97

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	/ төгрөгөөр / Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	626,762,940.00	(626,762,940.00)	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	626,762,940.00	(626,762,940.00)	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	527,340,582.00	(527,340,582.00)	
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,560,000.00	(2,560,000.00)	
210401	Бичиг хэрэг	-	830,000.00	(830,000.00)	
210402	Тээвэр, шатахуун	-	1,730,000.00	(1,730,000.00)	
2105	Нормативт зардал	-	850,000.00	(850,000.00)	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	850,000.00	(850,000.00)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	515,556,648.00	(515,556,648.00)	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	515,556,648.00	(515,556,648.00)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,373,934.00	(8,373,934.00)	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,373,934.00	(8,373,934.00)	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	99,422,358.00	(99,422,358.00)	
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	96,234,243.00	(96,234,243.00)	

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		96,234,243.00	(96,234,243.00)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,188,115.00	(3,188,115.00)	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,188,115.00	(3,188,115.00)	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	626,762,940.00	(626,762,940.00)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	626,762,940.00	(626,762,940.00)	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	427,776,530.00	(427,776,530.00)	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	198,986,410.00	(198,986,410.00)	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)				-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сайншанд сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Г.Тунгалагтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн тооллого хийх, чанар байдлыг тодорхойлж шийдвэрлүүлэх, акталсан хөрөнгийг устгах, дахин ашиглах талаар өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэх, ХАА зохион байгуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 04-өөс 2021 оны 02 дугаар сарын 10-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт ажилтан Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ний өдрийн 3/70 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хүний хөгжлийг дээдэлсэн, амьдрах таатай орчин бүрдүүлсэн, байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрлэл, аялал жуулчлалаар тэргүүлэгч, эдийн засгийн өндөр чадвартай, хөгжлийн тулгуур хот болох гэсэн эрхэм зорилго доор үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл: Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сайншанд сумын ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0,2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,043,214.1 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 2,086.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд нийт зардлын 2,419,420.6 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 4,838.8 мянган төгрөгөөр тооцож материаллаг байдлын хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайншанд сумын ЗДТГ 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,056,220.5 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	31,641.4	125,747.7	94,106.3
Урьдчилгаа	6,920.0	6,920.0	0
Бараа материал	201,898.2	207,439.1	5,540.9
Үндсэн хөрөнгө	6,856,617.3	7,813,190.6	956,573.3
Нийт хөрөнгө	7,097,076.9	8153297.4	1,056,220.5
Өр төлбөр	3,331.5	0	-3,331.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,093,745.4	8,153,297.4	1,653,065.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,097,076.9	8,153,297.4	1,056,220.5

Авлага дансны үлдэгдэл 125,747.7 мянган төгрөг болж 94,106.3 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 96,234.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн үлдэгдэл 180.7 мянган төгрөг нийт 96,414.9 мянган төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлснийг авлагаар тусгасан, Сайншанд сумын ЗАА-аас авах 9,900.0 мянган төгрөгийн авлага, 19,613.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага шинээр нэмэгдэж, өмнөх оны үлдэгдэл 31,641.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 207,439.1 мянган төгрөг болж 5,540.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуй материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны тусгай зориулалтын материалд 63.0 сая төгрөгийн /нэг бүр нь 105.0 мянган төгрөгийн үнэтэй 600 ширхэг/ байшин барилгын дугаарын тэмдэг, 16.2 сая төгрөгийн /нэг бүр нь 6.5 мянган төгрөгийн үнэтэй 2493 ширхэг/ хашааны тэмдэг бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,813,190.6 мянган төгрөг болж 956,573.3 мянган төгрөгөөр өссөн нь багийн иргэдийн хөгжлийн төвийн барилга, зам нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь нийт 1,761,374.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд хөрөнгө оруулалтаар 1,677,055.4 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар

13,557.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 70,761.7 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгөөс нийт 166,588.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсанаас 152,730.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэн, 13,857.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 3,331.5 мянган ХХОАТ-ын өрийг барагдуулж оны эцэст 0 үлдэгдэлтэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,153,297.4 мянган төгрөг болж 1,653,065.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Сайншанд сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,769,755.8 мянган төгрөгөөр буюу 49 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 170,515.2 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан гэрээт ажлын хөлс, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд байна. Энэ нь коронавируст халдварын голомтоос дамжин ирсэн иргэдийг тусгаарлах байр, хоолны үйлчилгээний төлбөр байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд хаасан 4,356.4 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь оны эхний үлдэгдэлд залруулга хийсэнтэй холбоотой. Үүнд: Өмнөх онд татвараас авах авлага 5,187.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгийн элэгдлийн зардал тооцох байсан 830.8 мянган төгрөгөөр бууруулах залруулга тус тус хийлгэсэн.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,149,682.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,149,682.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг ИТХ-аас 1,149,682.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,175,798.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,174,798.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 1,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,174,775.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 139.7 мянган төгрөг, нийт 1,174,915.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,174,734.8 мянган төгрөгийг зарцуулж 180.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

2020 онд 1,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 139.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 14 хувиар тасалсан байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Гэрчилгээний үнэ	1,000.0	139.7	-860.3	14.0
Нийт дүн	1,000.0	139.7		

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 427,776.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 198,986.4 мянга, нийт 626,762.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалд 3,410.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 523,930.6 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 3,188.1 мянга, нийт 530,528.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 96,234.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 137 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 229.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 8,109.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг цалингийн программын бодолттой тулгаж тайлагнах гэсэн 1 зөвлөмжийн хэрэгжилт 0 хувьтай байна. Тайлант онд Татварын хэлтэст ХХОАТ-ын 19,613.4 мянган төгрөг илүү шилжүүлж авлагатай гарсан.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	229.1	2	229.1	0	0	100
Албан шаардлага	2	8,109.4	2	8,109.4	0	0	100
Зөвлөмж	1		0		1		
Нийт дүн	5	8,338.5		8,338.5	1		0

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмжид албан шаардлага тогтоосон болно.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,256.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 20,256.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 2019 оны жилийн эцэст Татварын хэлтэст илүү шилжүүлсэн 5,187.2 мянган төгрөгийн авлагыг оны эхний үлдэгдэлд тайлагнаагүй байсныг өмнөх үеийн үр дүн дансанд залруулав.
2. Үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг оруулаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцоогүй байсан. Иймд өмнөх үеийн үр дүн дансанд 830.8 мянган төгрөг, тайлант оны элэгдлийн зардалд 3,873.5 мянган төгрөгийн нийт 4,704.3 мянган төгрөгийн залруулга хийлгэв.
3. Нэмэлт санхүүжилтийн дансанд орох 9,900.0 мянган төгрөгийн орлогыг Сайншанд сумын ЗАА-ны нэмэлт санхүүжилтийн дансанд оруулсан байна. Үүнийг авлага дансанд залруулав.
4. Цалингийн зардалд бичсэн 464.7 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд бичиж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 5 алдаа, зөрчил илэрснээс 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тооллого зохион байгуулах тухай ЗДТГ-ын даргын 2020.06.29-ний өдрийн А/32 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн тооллого хийсэн байна. 2020 оны 2 улирал, жилийн эцэст эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Жилийн эцсийн байдлаар нийт 207.4 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хуулийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 2/ "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан хугацаанд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн тооллого хийх гэсэн албан шаардлага өгөв.

2. Өмнөх аудитаар өгсөн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг цалингийн программын бодолттой тулгаж тайлагнах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Оны эцэст Татварын хэлтэст 19,613.4 мянган төгрөгийн ХХОАТ илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө ХХОАТ-ын төлбөр тооцоог хийж, өр авлага үүсгэхгүй ажиллах гэсэн албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3 алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Сайншанд сумын ЗДТГ-ын Тусгай зориулалтын материалын дансанд 63.0 сая төгрөгийн байшин барилгын дугаарын тэмдэг, 16.2 сая төгрөгийн хашааны тэмдэг нийт 79.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн 392.5 сая төгрөгийн 215 нэр төрлийн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1. "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн **ашиглах хугацаа нь дууссан** буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", АИТХТ-ийн 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журмын 3.3.2-т "Байгууллагын хөрөнгийн тооллогын комиссоос хагас бүтэн жилээр зохион байгуулсан тооллогын дүнг хэлэлцэж дутагдуулсан, **ашиглалтгүй байгаа, цаашид ашиглах шаардлагагүй, боломжгүй болсон хөрөнгийн шалтгааныг тогтоож**, дутагдуулсан, илүүдэлтэй хөрөнгийн жагсаалт гарган хэрхэн шийдвэрлэх талаар байгууллагын удирдлагад санал дүгнэлт хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

- 1.2. Эрсдэл: Дотоод хяналт сулрах, хөрөнгийн үр өгөөж буурах

- 1.3. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1 дэх заалт, аймгийн ИТХТ-ийн 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.3.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2.Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Сайншанд сумын ИТХ-ын 2020.06.25-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор 9.6 сая төгрөгийн 16 нэр төрлийн машин тоног төхөөрөмж, 2.1 сая төгрөгийн 11 нэр төрлийн тавилга эд хогшил, 2.1 сая төгрөгийн 7 программ хангамж нийт 13.8 сая төгрөгийн хөрөнгө акталж бүртгэлээс хассан байна. Акталсан хөрөнгийг устгаагүй байна.

Энэ нь аймгийн ИТХТ-ийн 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журамтай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Холбогдох хууль журам мөрдөгдөхгүй байх,

2.3. Өгсөн зөвлөмж: Байгууллагын данс бүртгэлээс хассан хөрөнгийг тодорхой үнээр худалдан борлуулах, устгах арга замыг өмч хамгаалах зөвлөлөөр шийдвэрлэж, агуулах, өрөө танхимыг чөлөөлөх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

3.Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Коронавируст халдварын голомтоос дамжин ирсэн иргэдийг тусгаарлах байр, хоолны зардлын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд ХАА зарлаагүй, үнийн санал авч харьцуулаагүй, шалгуур үзүүлэлтээр сонгон шалгаруулаагүй байна. МСҮТ, Аварга хөсөгтөн ХХК, Бадрах өргөө ХХК-д 152.3 сая төгрөгийн байр, хоолны зардлын мөнгө шилжүүлсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл: Худалдан авах ажиллагааны хууль зөрчигдөх

3.3. Өгсөн зөвлөмж: ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6.1-д заасан зарчмыг хэрэгжүүлж, ХАА зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Сайншанд сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/73/СТА-ТШЗТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Сайншанд сумын ЗДТГ	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй	-	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
2	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй	-	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
3	Элэгдлийн зардлаараа анхны үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
4	Акталсан хөрөнгийг устгаагүй	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
5	Коронавируст халдварын голомтоос дамжин ирсэн иргэдийг тусгаарлах байр, хоолны зардлын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд ХАА зарлаагүй, үнийн санал авч харьцуулаагүй	-	зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Г.Тунгалагтуяа, Г.Одончимэг
ДҮН		-			